



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 340

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2 нэрийн, нийт 29,135,350.00 (хорин есөн сая нэг зуун гучин таван мянга гурван зуун тавин) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг хавсралтад заасны дагуу цаашид ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоож “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Булган аймгийн Автотээврийн төв, “Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори” улсын төсөвт үйлдвэрийн газарт тус тус балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. “Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Ундрам, Булган аймгийн Автотээврийн төвийн дарга Ж.Батзориг, “Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Б.Ганзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарыг шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын  
газрын 2020 оны 07 дугаар сарын 06-ний  
өдрийн 340 дүгээр тогтоолын хавсралт



**"Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар" ТӨҮГ-ын үндсэн  
хөрөнгөд бүртгэлтэй цаашид ашиглах жил үнийг шинэчлэн тогтоож балансаас  
балансад шилжүүлэх үндсэн хөрөнгийн жагсаалт**

| № | Эд хөрөнгийн нэр                                                                                               | Ашиглал<br>танд<br>орсон<br>огноо | Балансын,<br>хуримтлагдсан<br>элэгдлийн дүн<br>(төгрөг)                                    | Шинэчлэн<br>тогтоох үнэ                 | Цаашид<br>ашиглах<br>хугацаа | Хүлээж авах<br>байгууллага                           |
|---|----------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------|--------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------|------------------------------|------------------------------------------------------|
| 1 | Ниссан х-трайл<br>маркийн, УНО 71-72<br>улсын дугаартай,<br>суудлын автомашин,<br>арлын дугаар -<br>NT30054484 | 2011                              | 18,120,000.00                                                                              | 9,000,000.00                            | 4 жил                        | "АТҮТ" ТӨҮГ-ын<br>Булган аймгийн<br>Автотээврийн төв |
| 2 | Соната маркийн, УБГ<br>03-35 улсын<br>дугаартай, суудлын<br>автомашин, арлын<br>дугаар -<br>КМНЕВ41ВВСА395390  | 2011                              | 11,015,350.00                                                                              | 7,000,000.00                            | 4 жил                        | Улсын мал<br>эмнэлэг, ариун<br>цэврийн<br>лабратори  |
|   |                                                                                                                |                                   | 29,135,350.00                                                                              | 16,000,000.00                           |                              |                                                      |
|   | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                                                                      |                                   | 29,135,350.00<br>(хорин есөн сая<br>нэг зуун гучин<br>таван мянга<br>гурван зуун<br>тавин) | 16,000,000.00<br>(арван зургаан<br>сая) |                              |                                                      |